

БАТЛАВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.ГАНЦЭЦЭГ

МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
АЖИЛТНЫ ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ
ДАРГА



Б.МЯГМАР

Хамтран ажиллах гэрээ

2019 оны 03 дугаар сарын 28

№

2019 03 28 150

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1. Нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв цаашид /санхүүжүүлэгч/ гэх нөгөө талаас Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо цаашид /гүйцэтгэгч/ гэх талууд хамтран Эрүүл мэндийн салбарын “эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал”-ын судалгааг нийслэлийн харьяа дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн түвшинд хамтран хийж гүйцэтгэнэ.
2. Талууд хамтран ажиллах гэрээний хүрээнд гүйцэтгэх ажлын дарааллыг тодорхойлж, төлөвлөгөө гарган хамтран хэрэгжүүлнэ. Өөрөөр зохицуулах шаардлага гарвал талуудын хооронд нэмэлт гэрээ, хэлцэл байгуулж болно.
4. Гэрээгээр гүйцэтгэх ажлын санхүүжилтэд судалгааны ажлын асуумж боловсруулах, судалгааны ажлыг гүйцэтгэх хүн хүч, техник хэрэгсэл, замын зардал, судалгааг нэгтгэх ажлын хөлс зэрэг багтана.
5. Гэрээгээр гүйцэтгэх ажлын явцад түүний санхүүжилтийн хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарвал талуудын хооронд нэмэлт гэрээ хэлцэл байгуулж болно.
6. Гэрээгээр гүйцэтгэх ажлын зардлын төсөв нь гэрээний салшгүй хэсэг байна.
7. Гэрээгээр гүйцэтгэх судалгааны ажлыг талууд энэ оны 9 сард багтаан хэрэгжүүлнэ.


Хоёр. Талуудын үүрэг, эрх, хариуцлага

2.1. Санхүүжүүлэгч дор дурдсан үүрэг хүлээнэ:

- а) Гэрээний хавсралтаар батлагдсан зардлын төсөв болох нийт 4 900 000 төгрөгийг Монголын эрүүл мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны голомт банк дахь 1102101985 тоот дансанд 2019 оны 03 сарын 29-ны дотор саадгүй шилжүүлэх
- б) Гэрээнд заасан хугацаанд зардлыг санхүүжүүлэх
- в) Санхүүжүүлэхдээ гэрээгээр гүйцэтгэх судалгааны ажлын зардлын төсөвт хяналт тавих
- д) Судалгааны ажлын зардлын зарцуулалтын байдалд санхүүжүүлэгчийн зүгээс хяналт тавьж, гарсан дутагдал, зөрчлийг тухай бүр арилгах арга хэмжээ авах
- е) Гэрээгээр гүйцэтгэх ажил дууссаны дараа судалгааны тайлан, санхүүгийн тайлан тооцоог зохих журмын дагуу бүрэн гүйцэд хүлээн авах

2.2. Гүйцэтгэгч дор дурдсан үүрэг хүлээнэ:

- а) Гэрээгээр гүйцэтгэх ажлыг бүрэн гүйцэтгэх, үр дүнг тоо, чанарын өндөр түвшинд хийх
- б) Зардлыг оновчтой хэлбэрээр хуваарилаж, үр ашигтай зарцуулах
- в) Хамтран гүйцэтгэж буй ажлын үр дүнгийн талаар мэдээллэж байх



2.3 Санхүүжүүлэгч дор дурдсан эрх эдэлнэ:

- а) Гэрээний ажлын гүйцэтгэл, үр дүн, түүний баталгаажуулалт, хөрөнгө зардлын зарцуулалт, ашиглалт зэрэг асуудлаар захиалагчаас мэдээ, тайлан гаргуулж авах, гэрээний үүргийг биелүүлэх, зөрчил дутагдлыг арилгах талаар түүнд анхааруулах, шаардлага тавьж шийдвэрлүүлэх
- б) Санхүүгийн тайлан мэдээг хожимдуулах, санхүүгийн үйл ажиллагааг буруу явуулах, хөрөнгө мөнгийг буруу зүйлд зарцуулах, санхүүжилтийн бус шалтгаанаар ажил удааширах, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй тохиолдолд санхүүжилтийг түр зогсоох, улмаар шаардлагатай гэж үзвэл судалгааг зогсоох санал тавих зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.4 Гүйцэтгэгч дор дурдсан эрх эдэлнэ:

- а/ Гэрээгээр гүйцэтгэх судалгааны ажлын хүрээнд санхүүжүүлэгчээс удирлага, зохион байгуулалтын хувьд зохих хэмжээний дэмжлэг туслалцаа авах
- б/ Судалгааны ажлыг зохион байгуулах нөхцөл бололцоогоор бүрэн хангахыг шаардах

2.5 Хариуцлага

Үүргээ биелүүлээгүй талын хүлээх хариуцлагыг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

3. Гэрээ хүчин төгөлдөр байх

3.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.

3.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд / дараах хувилбарын аль нэгийг сонгож болно/

- харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

- онцгой нөхцөл шалтгаан бий болсон үед гэрээний аль нэг тал 1 сарын өмнө мэдэгдэж гэрээнээс татгалзаж болно.

3.3. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг талууд зөвшилцөн шийдвэрлэнэ. Эс зөвшилцвөл асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

4 Гэрээ байгуулсан:

Хаяг: СБДүүрэг 1-р хороо Энхтайвны
Гудамж 13в корпус

Утас: 320633

Албан тушаал: ХНБЗ Албаны дарга
Т.Учрал
Гарын үсэг: _____

Хаяг: Чингэлтэй дүүрэг 1-р хороо
МҮЭХолбооны төв байр 301 тоот

Утас: 320549

Албан тушаал: Дэд дарга
Ч.Нарантуяа
Гарын үсэг: 